national life

# 2022 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН



national life

# КОМПАНИЙН ТУХАЙ



**ТУЙЛЫН ЗОРИЛГО:**

Хэрэглэгч, ажилтан, хувьцаа эзэмшигч харилцан үнэ цэнийг бүтээнэ.

**ХЭТИЙН ЗОРИЛГО:**

Амьдралын даатгалын үйл ажиллагаагаар өрх бүрийн зорилгодоо хүрэх санхүүгийн баталгааг бий болгож нийгэмд хүртээмжтэй үнэ цэнийг бүтээнэ.

**ЗАРЧИМ:**

1. Нэгдмэл зорилгодоо захирагд
2. Үүргээ биелүүлж үр шимээ хүрт
3. Ил тод бай
4. Баримт, нотолгоонд үндэслэ
5. Тасралтгүй сайжир

**ҮНЭТ ЗҮЙЛС:**

1. Тууштай түншлэл
2. Цэгцтэй сэтгэлгээ
3. Хүртээмжтэй шийдэл

**КОМПАНИЙН ЭРХЭЛДЭГ ДААТГАЛЫН ХЭЛБЭРҮҮД:**



## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

**2007** Монголын анхны амьдралын даатгалын компани болж байгуулагдав.

**2008** Олон улсын эмнэлгийн болон аяллын түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэгч “International SOS" компанитай хамтран ажиллаж эхлэв.
Германы Munich Re компанитай хамтран ажиллаж, компанийн найдвартай ажиллагааг баталгаажуулав.

2010 Хувийн тэтгэврийн даатгалын үйлчилгээг нэвтрүүлэв.

2011 Өөрийн оффисийг барьж ашиглалтанд оруулав.

2013 Хүнд өвчний даатгалыг нэвтрүүлэв.

2014 Насан туршийн амьдралын даатгалыг нэвтрүүлэв.

2017 Эрүүл мэндийн даатгалын хамгийн өндөр нөхөн төлбөрийг нэг даатгуулагчид олгосон компани болов.

2018 Хорт хавдрын даатгалыг нэвтрүүлэв.

2020 Даатгалын хураамжийг буцаах нөхцөлийг нэвтрүүлэв

2021 Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001;2015 нэвтрүүлж SFC XXK-аар баталгаажуулав.

## ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН




## КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



national life

# 2022 ОНД БИД



**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

Нэйшнл лайф даатгал ХХК нь 2022 онд “Даатгалд хамруулах, хөрөнгө оруулах, ажилтныг урт хугацаанд үр дүнтэй ажиллуулах, хэрэглэгчийн шалгуурыг хангах шийдлүүдийг төгөлдөржүүлэх замаар даатгалын хүртээмжийг нэмэгдүүлнэ” зорилгыг тодорхойлж ажиллалаа.

Компани нь 2022 онд 2,082,729,908 төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 2,7 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлж 130,67% биелэлттэй, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 52 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна..




Компанийн 2022 онд төвлөрүүлсэн байгууллагын даатгалын хураамжийн орлогын 95.9 хувиар, хувь хүний даатгалын хураамжийн орлого 0.53 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Компанийн 2022 онд төвлөрүүлсэн байгууллагын даатгалын хураамжийн орлогын 95.9 хувиар, хувь хүний даатгалын хураамжийн орлого 0.53 хувиар буурсан үзүүллэлттэй байна.

national life

## Хураамжийн орлого: /байгууллага, хувь хүнээр/

| № | Үзүүлэлт | 2021 он | 2022 он | Өсөлт/бууралт |
|---|---|---|---|---|
| 1 | **Даатгалын хураамж** | **1,791,792,110** | **2,723,660,770** | **52.01%** |
| 2.1 | **Байгууллага** | **1,040,473,027** | **2,038,201,824** | **95.89%** |
| | Эрүүл мэндийн даатгал | 768,019,034 | 1,363,816,497 | **77.58%** |
| | Хуримтлалын даатгал | 75,252,205 | 202,656,004 | **169.30%** |
| | Амь нас, гэнэтийн ослын даатгал | 197,201,788 | 471,729,323 | **139.21%** |
| 2.2 | **Хувь хүн** | **689,092,559** | **685,458,945** | **-0.53%** |
| | Эрүүл мэндийн даатгал | 38,897,340 | 33,395,805 | **-14.14%** |
| | Хуримтлалын даатгал | 634,710,369 | 608,908,883 | **4.07%** |
| | Амь нас, гэнэтийн ослын даатгал | 15,484,850 | 43,154,258 | **178.69%** |
| | Ковидын даатгал | 62,226,524 | 0 | **-100.00%** |

48

Компани нь 2022 онд 908.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын орлого төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 1,030.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын орлого төвлөрүүлж 113.4 % биелэлттэй , өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.6% - н өссөн үзүүлэлттэй байна.



national life

**Хөрөнгө оруулалтын орлогын гүйцэтгэл /хөрөнгө оруулалтын хэрэгслээр /**

| Үзүүлэлт | 2021 он | 2022 он | Өсөлт/бууралт |
|---|---|---|---|
| Түрээсийн орлого | 49,473,376 | 36,000,000 | **-27.23%** |
| Хадгаламжийн хүү | 321,237,569 | 211,520,112 | **-34.2%** |
| Хуримтлал бүрдүүлсэн [illegible] хүүгийн орлого | - | 512,231 | - |
| Компанийн бонд | 335,249,644 | 218,203,639 | **-34.9%** |
| Итгэлцлийн үйлчилгээний хүүгийн орлого | 181,400,767 | 314,484,131 | **73.4%** |
| ХБҮЦ-ны хүүгийн орлого | 85,568,964 | 72,768,423 | **-15.0%** |
| Хувьцаа, үнэт цаас, валютын ханшийн зөрүүний олз/гарз | 3,193 | 175,989,615 | **5,179,217.7%** |
| Төслийн орлого | - | 746,550 | - |
| **Нийт** | **984,828,947** | **1,030,220,701** | **4.6%** |

50

Компани нь 2022 онд 1,3 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг даатгуулагчид олгосон байна.




Компани нь 2022 онд Энхжин эрүүл мэндийн даатгал, Аавын даатгал, Баталгаат амьдрал амьдрал хамт олны даатгал, Зорилго той хуримтлалын даатгалын бүтээгдэхүүнийг Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэн зах зээлд шинээр нэвтрүүллээ.

## national life 2022 онд зах зээлд нэвтрүүлсэн шинэ бүтээгдэхүүнүүд




## national life Аавын даатгал



“Аавын даатгал” нь эрэгтэй хүмүүсийн зонхилон өвчилдөг өвчнүүдийн хамгаалалттай ба эмнэлгийн тусламж үйлчилгээг өөрийн хүссэн эмнэлэгт цаг алдалгүй, санхүү мөнгөний бэрхшээлгүйгээр эмчлэгдэн эдгэрэх боломжийг олгодог даатгал юм.

| Багц 1 | Багц 2 |
|---|---|
| 25,000,000₮ | 50,000,000₮ |
| Монгол улс | |




- Зүрхний шигдээс
- Тархины цус харвалт
- Элэгний хорт хавдар
- Ходоодны хорт хавдар
- Түрүү булчирхайн хорт хавдар
- Уушгины хорт хавдар

## national life Баталгаат амьдралын хамт олны даатгал



“Баталгаат амьдрал хамт олны даатгал” нь ердийн өвчин, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин, ахуйн ослын улмаас амь нас эрсдэх, хөдөлмөрийн чадвараа алдах тохиолдолд цаг хугацаа, газар зүйн хязгаарлалтгүйгээр дэлхий дахинд 24 цагийн турш гэр бүлд үүсэх санхүүгийн эрсдэлээс хамгаална.



**national life** Зорилготой хуримтлалын даатгал



“Зорилготой хуримтлалын даатгал” нь зорилгоо биелүүлэхэд хэрэгцээтэй мөнгөн хуримтлалыг бий болгох замын хоточ юм.

| Нохцол | Тогтвортой хуримтлуулагч | Зоригтой хуримтлуулагч |
|---|---|---|
| Бүтээгдэхүүний онцлог шинжийг тусгасан нэр | *Баталгаат өгөөжийн түвшинтэй тогтвортой байдлыг эрхэмлэгч* | *Эрсдэл даах чадвартай эрсдэлд дурлагч* |
| Зорилтот өгөөж | 15% | 18.5% |
| Баталгаат өгөөж | МББ хүү | байхгүй |



Нэйшнл лайф даатгал ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд “Ганцхан шалтгаан” уран сайхны кинод ерөнхий ивээн тэтгэгчээр оролцлоо.



**КОМПАНИД ҮНЭ ЦЭН БҮТЭЭСЭН АЖИЛТНУУДДАА ХУВЬЦАА ЭЗЭМШҮҮЛЛЭЭ.**

Олон улсад энэ хөтөлбөрийг хэрэгжүүлсэн компаниудын туршлагаас харахад компанийн хувьцааны үнийг тогтвортой байлгах, компанийн үнэлгээг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой хөтөлбөр болсон байдаг.
2022 оны 11-р сарын 23-ны өдөр компанийнхаа түүхэн хөгжилд хувь нэмэр оруулж үнэ цэн бүтээлцсэн 50 ажилтанд хувьцаа эзэмшүүлэх батламж гардууллаа.



## СИСТЕМИЙН ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Нэйшнл лайф даатгал ХХК нь компанийн үйл ажиллагааны үр дүнг хэрэглэгчид бүтээсэн үнэ цэн, хөдөлмөрийн бүтээмж, ажилтны цалин хөлс хангамжийн багц, зардлын бүтээмж, хөрөнгийн бүтээмж- хураамжийн орлого, хөрөнгө бүтээмж-хөрөнгө оруулалтын орлого гэсэн 6 үзүүлэлтээр хэмждэг бөгөөд компанийн СҮДҮ-ийн гүйцэтгэл 121.1 хувийн гүйцэлтэй гарч 2021 онтой харьцуулахад гүйцэтгэлийн түвшин 19.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

national life

**СҮДҮ-н гүйцэтгэл**

| № | СҮДҮ-н үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | 2021.IV | | | 2022.IV | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Биелэлт % | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Биелэлт % |
| 1 | Хэрэглэгчдэд бүтээсэн үнэ цэнэ | мян.төг | 1,789,632.162 | 1,503,231.511 | **84.0%** | 2,372,244.460 | 3,018,375.626 | **127.2%** |
| 2 | Хөдөлмөрийн бүтээмж | мян.төг/ хүн цаг | 31.930 | 33.857 | **106.0%** | 34.882 | 50.620 | **145.1%** |
| 3 | Ажилтны цалин хөлс, хангамжийн багц | мян.төг/ цаг | 12.517 | 14.053 | **106.0%** | 13.401 | 15.423 | **115.1%** |
| 4 | Зардлын бүтээмж | төг/төг | 0.97 | 0.597 | **61.4%** | 1.160 | 1.109 | **95.5%** |
| 5 | Хөрөнгийн бүтээмж- Хур/О | төг/төг | 0.150 | 0.143 | **95.5%** | 0.206 | 0.271 | **131.3%** |
| 6 | Хөрөнгийн бүтээмж- ХОО | төг/төг | 0.082 | 0.084 | **101.4%** | 0.09 | 0.103 | **113.9%** |
| **СҮДҮ-ийн дундаж үзүүлэлт** | | | | | **91.2%** | | | **121.1%** |

52

Компанийн хэмжээнд 2022 онд нийт 1023 ажил төлөвлөснөөс 989 ажлыг гүйцэтгэлээ.

national life

## 2022 оны ЖУАТ-ний гүйцэтгэл

| № | Үзүүлэлтүүд | 2021 ОН | 2022 он |
|---|---|---|---|
| 1 | Нийт ажлын тоо | 1153 | 989 |
| 1.1 | ЖУАТ-д тусгасан төлөвлөгөөт ажил | 1081 | 912 |
| 1.2 | ПА ажлын тоо | 72 | 77 |
| 2 | Зохицуулалт хийсэн ажлын тоо | 30 | 34 |
| 2.1 | Зохицуулалт хийж хугацааг хойшлуулсан | 26 | 25 |
| 2.2 | Зохицуулалт хийж УАТ-с хассан ажлын тоо | 3 | 9 |
| 2.3 | Тасарсан ажлын хугацааг хойшлуулсан | 1 | 0 |

Компанийн хүрээнд ажилтнуудыг үүргийн гүйцэтгэлийг Системийн үйл ажиллагааны гүйцэтгэлээр хэмждэг бөгөөд 2022 онд САГҮ-ийн гүйцэтгэл 99.74 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.4 хувиар өссөн байна.

national life

## 2022 оны САГҮ-ийн гүйцэтгэл




САГҮ тайлан

2020 оны дундаж САГҮ 99.7%
2021 оны дундаж САГҮ 99.34%
2022 оны дундаж САГҮ 99.74%

Компанийн Оношилгооны зөвлөлөөр 235 асуудлын шалтгааныг илрүүлэх оношилгоо хийжээ. Үүнд:




## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталж, хоёр их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгож, Компанийн үзэл баримтлал болон дунд хугацааны зорилтыг шинэчлэн батлах, ТУЗ-ийн хараат бус гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх зэрэг 9 асуудал хэлэлцэж шийдвэрлэв.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2022 онд 63 асуудал хэлэлцэж 53 асуудлыг баталж, 10 асуудлыг буцааж шийдвэрлэв.

# Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр

## Хэлэлцүүлсэн асуудлыг шийдвэрлэсэн байдал







| | Баталсан | Буцаасан |
|---|---|---|
| | Баталсан | Буцаасан |
| 2022.01 | 22 | 0 |
| 2022.02 | 6 | 3 |
| 2022.03 | 9 | 0 |
| 2023.04 | 20 | 7 |

| | Баталсан | Буцаасан |
|---|---|---|
| 2019 | 41 | 0 |
| 2020 | 76 | 13 |
| 2021 | 105 | 12 |
| 2022 | 53 | 10 |